**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт” –д хийсэн нийцлийн аудитын тайлан /ДУА-2018-02-НА/









***Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг бууруулж, хамрагдах малын тоог багасгаж байгаа нь өвчлөл нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.***

**2018 он**

**АГУУЛГА**


| | |
|---|---|
| Товчилсон үгс | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, аргазүй, үндсэн мэдээлэл | 4-7 |
| **Бүлэг 1. Батлагдсан төсвийг МЭҮН-д хуваарилах тогтоосон заавар, аргачлал байхгүй, вакцины бүртгэл хөтлөлт, түүнд тавих хяналт хангалтгүй байна** | |
| 1.1 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс зарцуулах төсвийн саналыг 2014-2018 онд 30.2-59.6 хувиар бууруулан баталжээ. | 8-9 |
| 1.2 Батлагдсан төсвийг МЭҮН-дэд хуваарилах тогтоосон заавар, аргачлал байдаггүйгээс зардлыг бодитой хуваарилахгүй байна. | 10 |
| 1.3 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж байгаа ч вакцины орлого, зарлагыг хөтлөөгүйгээс 3,171.0 мянган төгрөгийн вакцин бүртгэлгүй байна. | 11-13 |
| **Бүлэг 2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт муу хийгдэж байгаагаас зарим үйл ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулагдахгүй байна.** | |
| 2.1 Хөдөө орон нутагт ХАА-н мэргэжлийн боловсон хүчин дутмагаас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулж чадахгүй байна. | 13-16 |
| 2.2 Мал эмнэлгийн эм, биобэлдмэлийн ашиглалт, зарцуулалт, хадгалалтад тавих бүх шатны хяналт хангалтгүй байна. | 16-17 |
| Дүгнэлт | 18 |
| Зөвлөмж | 18-19 |
| Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар | 20 |
| Тайлан баталгаажуулах тушаал | 21-29 |
| Тайлангийн хавсралтууд | 30-35 |



Тайланг бэлтгэсэн:

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа

Аудитын менежер Х.Наранцацрал

Ахлах аудитор Д.Ихбаяр

Аудитор Д.Должинсүрэн

**Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592225 дугаарын утсаар харилцана уу.**

Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү.

**www.audit.mn**

**Хаяг:** Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 2 давхар


**2018 оны 8 дугаар сар**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **УИХ** | Улсын Их Хурал |
| **ИТХ** | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| **АДБОУС** | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| **ЗДТГ** | Засаг даргын Тамгын газар |
| **ХХААГ** | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| **МХГ** | Мэргэжлийн хяналтын газар |
| **МЭҮН** | Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |
| **МЭҮТ** | Мал эмнэлгийн үйлчилгээний тасаг |
| **ЗГ** | Засгийн газар |
| **ИТХТ** | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид |
| **УМЭҮГ** | Улсын мал эмнэлэг, үржлийн газар |
| **МЭУСАХ** | Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ |
| **ОХУ** | Оросын холбооны улс |
| **ХХАА** | Хүнс, хөдөө аж ахуй |
| **ЗД** | Засаг дарга |
| **МЭА** | Мал эмнэлгийн алба |
| | |

## ГРАФИК БОЛОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ


| | |
|---|---|
| **График 1** | Мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, боловсон хүчний судалгаа /тоогоор/ |
| **График 2** | Нэг МЭҮН болон малын эмчид ногдох малын тоо |
| **График 3** | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хамралтын хувь /2016-2018/ |
| **График 4** | Малын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийн харьцуулалт /2014-2018 он, сая төгрөг/ |
| **График 5** | Малын тооны харьцуулалт аймгийн дүнгээр /2014-2017 он/ |
| **График 6** | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хамрагдах бог мал, бод малын тооны өөрчлөлт /2016-2018 / |
| **График 7** | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарцуулалт /2015-2017 он, мян.төг / |
| **График 8** | Мэргэжлийн хяналтын төлөвлөгөөт шалгалтаар |
| **Хүснэгт 1** | Өвчилсөн малын судалгаа /8 жилээр/ |
| **Хүснэгт 2** | Хонины цэцэг өвчний 2016 оны вакцины зарцуулалт |
| **Хүснэгт 3** | Хонины цэцэг өвчний 2017 оны вакцины зарцуулалт |
| **Хүснэгт 4** | Сумдын боловсон хүчний судалгаа |

## АУДИТЫН НЭР: *“МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ”*

## АУДИТЫН КОД: ДУАГ-2018-02-НА

## АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөө”, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт болон түүнд тавих хяналт хууль, журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

## ДЭД ЗОРИЛТ

- Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж, зарцуулж байгаа эсэх;
- Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль, журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж байгаа эсэх.

## АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Аймаг, сумын ЗДТГ, ХХААГ, 15 сумын Мал эмнэлгийн албаны мэргэжилтнүүд, МХГ-ын байцаагч нар болон хувийн МЭҮН-ийн хүлээн авсан баримт материал, аймаг, сумдын эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан тушаал, шийдвэрүүд, 2015-2017 оны санхүүгийн баримт материалууд, холбогдох бусад эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

## АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4100 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлав.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгах, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах арга зүйг ашиглалаа.

АДБОУС, Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Аудитын Олон Улсын стандарт;
- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль;
- ЗГ-ын 2008 оны 305 дугаар тогтоолоор батлагдсан “Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журам”;
- ЗГ-ын 2016 оны 240 дугаар тогтоолоор батлагдсан “Гоц халдварт өвчинтэй тэмцэх бүс тогтоох, уг бүсэд мал эмнэлэг, хорио цээрийн үйл ажиллагаа явуулах журам”;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 161 дугаар тогтоолоор батлагдсан ”Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээний жагсаалт”;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 20 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээ, нэг малын эмчид ногдох малын тоо”;
- Аймгийн Засаг даргын 2013 оны А/284 захирамжаар батлагдсан “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг олгох, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах журам”.

## АУДИТЫН ХУГАЦАА, БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2018 оны 06 дугаар сарын 25 –ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар хийж гүйцэтгэлээ.

## АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж, зарцуулж байгаа эсэх, хоёрдугаар бүлэгт мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж байгаа эсэх талаар тусгаж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

## АУДИТЫН ЯВЦАД ТУЛГАРСАН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Аудитын явцад аймгийн ХХААГ-ын Мал эмнэлэг үржлийн албаны хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд мэдээ, судалгаа, баримт материалыг шаардсан хугацаанд

ирүүлээгүй, ирүүлсэн зарим мэдээлэл нь шаардлага хангахгүй байсан зэргээс аудитын хөтөлбөрийн хугацаа алдагдахад хүрсэн.

Аудитын явцад мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавиагүй,эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан ХХААГ-ын Мал эмнэлгийн албаны дарга М.Хүүбаян, Халдварт паразиттах өвчин хариуцсан мэргэжилтэн Ц.Гэрэл, Лабораторийн эрхлэгч А.Оюунцэцэг, Халдваргүй өвчин, мэдээ мэдээлэл, эм био бэлдмэл, эмийн сан, ариутгал, халдваргүйтэл хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэцэцэг, дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн О.Ганцэцэг болон 6 сумын ЗДТГ-ын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мал эмнэлгийн мэргэжилтнүүд болон хяналтын улсын байцаагч нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг харьяа байгууллагын удирдлагад нь хүргүүллээ.

## АУДИТЫН ДҮН

Аудитаар нийт 6,493.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 9.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулж, 2,579.0 мянган төгрөгийн хохирлыг барагдуулахаар хугацаатай төлбөрийн акт тогтоож, 3,905.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, 11 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах хугацаатай албан шаардлага, шүлхийгийн вакцины илүүдэлтэй холбоотой зөрчлийг шалгуулахаар аймгийн Цагдаагийн газарт албан тоот хүргүүллээ.

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээний жагсаалтыг аймгийн ИТХ-ын 2014 оны 161 дугаар тогтоолоор баталж, 2017 оны 20 дугаар тогтоолоор Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээ, нэг малын эмчид ногдох малын тоог шинэчлэн тогтоосон байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны А/284 дугаар захирамжаар “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг олгох, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах журам”-ыг батлан мөрдөж ажиллаж байна.

График 1




Мал эмнэлгийн албаны орон тоо 2017 онд 8 болон өсч, 15 сумын ЗДТГ-ын МЭҮТ-т малын эмчийн орон тоо 2015 оноос 2017 оны хооронд 41.6 хувь буюу 5 орон тоогоор буурч, МЭҮН-ийн тоо 2015 оноос 20 хувь буюу 5 байгууллагаар нэмэгдэж, 2017 оны байдлаар 30 нэгжид их эмч 40, бага эмч 15 нийт 85 малын эмч ажиллаж мал эмнэлгийн ажил үйлчилгээг үзүүлж байна.

График 2




Сүүлийн жилүүдэд МЭҮН нэмэгдэж байгаа ч малын тоо толгой өссөн учраас 2015 онд нэг МЭҮН-д 94.5 мянган толгой мал ноогдож байсан бол 2017 онд 26.6 хувь буюу нэг МЭҮН-д 119.7 мянган толгой мал, нэг их эмчид 2015 онд 71.5 мянган толгой мал ноогдож байсан бол 2017 онд 79.8 мянган толгой мал буюу 11.6 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд гарсан өвчлөлтэй харьцуулахад аймгийн малын өвчлөл, хорогдол харьцангүй бага, халдварт өвчнөөр өвчилсөн малын тоо толгой сүүлийн жилүүдэд буурсан байна. Харин галзуу, шөвөг яр, дотрын халдварт хордлого, сахуу, дуут хавдар, цусан халдварт, колибактериоз зэрэг өвчин нэмж бүртгэгдэж, паразитах, халдваргүй өвчнөөр өвчилсөн малын тоо нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байгаа нь ширхтэх, хачигтах зэрэг өвчнөөр олон мал өвчилсөнтэй холбоотой байна.

Хүснэгт №1 Өвчилсөн малын судалгаа

| | **Өвчилсөн мал** | | | | **Хорогдсон мал** | | | | **Эдгэрсэн** | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Халдварт | Паразит | Халдваргүй | Бүгд | Халдварт | Паразит | Халдваргүй | Бүгд | Халдварт | Паразит | Халдваргүй |
| **2010** | 8517 | 161 | 4732 | 3624 | 3274 | 146 | | 3128 | 5243 | 15 | 4732 | 496 |
| **2011** | 20564 | 345 | 18425 | 1794 | 265 | 88 | 9 | 168 | 8252 | 257 | 18416 | 1626 |
| **2012** | 38782 | 447 | 34565 | 3770 | 331 | 12 | 14 | 305 | 38451 | 435 | 34551 | 3465 |
| **2013** | 28507 | 294 | 22608 | 5605 | 399 | 29 | 4 | 366 | 28108 | 265 | 22604 | 5239 |
| **2014** | 66782 | 1235 | 59593 | 5954 | 1311 | 134 | 11 | 1166 | 65471 | 1101 | 5582 | 4788 |
| **2015** | 23671 | 317 | 20559 | 10927 | 1698 | 43 | 25 | 1630 | 30100 | 269 | 20534 | 9297 |
| **2016** | 37402 | 4086 | 18665 | 14651 | 2063 | 10 | 8 | 2045 | 34768 | 3505 | 18657 | 12606 |
| **2017** | 12891 | 1004 | 10987 | 900 | 445 | 315 | 3 | 127 | 12446 | 689 | 10984 | 773 |

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 7 нэр төрлийн вакцин ийлдэсийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захиалгыг үндэслэн 2017 онд 723.1 мянган толгой малд хийхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 758.9 мянган толгой малд хийж, үйлчилгээний хөлсөнд 228,790.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон байна.

Харин гоц халдварт бруцеллёз өвчний үйлчилгээний хөлсөнд 127,279.4 мянган төгрөгийн, "Цэцэг" өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 2,934.9 мянган хонинд хийж, 440,239.9 мянган төгрөгийн, "Шүлхий" өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 1,174.8 мянган малд хийж, 179,398.2 мянган төгрөгийн хөлсийг улсын төсвөөс тус тус олгосон байна.

## **БҮЛЭГ 1.** Батлагдсан төсвийг МЭҮН-д хуваарилах тогтоосон заавар, аргачлал байхгүй, вакцины бүртгэл хөтлөлт, түүнд тавих хяналт хангалтгүй байна

### 1.1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс зарцуулах төсвийн саналыг 2014-2018 онд 30.2-59.6 хувиар бууруулан баталжээ.

Аймгийн ХХААГ-ын Мал эмнэлгийн алба нь Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[1], аймгийн Засаг даргын 2013 оны А/284 дүгээр захирамжаар батлагдсан "Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг олгох, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах журам"-ын 2.2.1[2]-дзаасны дагуу халдварт өвчний вакцинжуулалтад хамрагдах мал, амьтны тоо, тэдгээрт шаардагдах вакцины захиалгыг улсын Мал эмнэлгийн үржлийн газраар жил бүр хянуулж, үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс олгохоор төлөвлөн батлуулж ирсэн байна.

Сүүлийн жилүүдэд Дундговь аймагт малын халдварт өвчин бага гардаг гэсэн шалтгаанаар хүргүүлж буй төсвийн саналыг Сангийн яамнаас бууруулан ирүүлж аймгийн ИТХ- аар баталж ирсэн байна.

Мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хамралтыг сүүлийн 3 жилээр авч үзэхэд нийт тоологдсон малын 19.4-32.1 хувь нь халдварт өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдахаар байгаа бөгөөд жил ирэх тусам малын хамралт буурсан байна. Хавсралт № 1, График № 3




Иймээс хамрагдвал зохих мал, амьтад урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдаж чадахгүй, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1[3].-д заасан аймгийн Засаг даргын бүрэн эрх хязгаарлагдаж, малын халдварт өвчлөл нэмэгдэх эрсдэлтэй байна.

МЭҮН-үүдээс 2011-2015 онд ирүүлсэн төсвийн саналыг батлагдсан төсөвтэй нь харьцуулж графикаар харуулбал:

График № 4



График №4-ээс харахад 2014-2016 оны батлагдсан төсөв 7.4-9.1 хувиар өсөж 2017 онд буурсан харагдаж байгаа боловч, 2014-2018 онд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын захиалгын тоог 330.2-772.3 мянган толгойгоор, төсвийн саналыг 90.2-347.5 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Мөн мал аж ахуйн салбарт бий болж байгаа өөрчлөлт шаардлагыг үл харгалзан урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 2017 онд өмнөх оноос 11.6 сая төгрөгөөр бууруулж, 2018 онд өмнөх оны төсөвтэй ижил хэмжээнд баталж байна.

*Тухайлбал:*

- *Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 20-р тогтоолоор "Төрөөс зардлыг хариуцах мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээ"-г шинэчлэн баталж, бод малд вакцин, био бэлдмэл тарих үйлчилгээний хөлсийг 150 төгрөгөөр нэмэгдүүлж баталсан боловч 2018 оны төсөв өмнөх жилийн төсөвтэй ижил хэмжээнд батлагдсан байна.*
- *Аймгийн хэмжээнд 2014-2017 онд малын тоо 299.5- 533.1 мянган толгойгоор буюу 32.2 хувиар өссөн боловч төсвийг нэмэгдүүлээгүй.*

График № 5




Энэ нь аймгийн ИТХ Сангийн яамнаас тогтоосон төсвийн хэмжээг бодит нөхцөл байдалд болон төсвийн саналд тулгуурлан өөрчлөх эрхгүйгээр шууд баталж байгаатай холбоотой байна.

Харин Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1[4]-д заасны дагуу малын гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, 15.1.2[5]-д заасны дагуу халдварт ба гоц халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах эм, биобэлдмэлийн үнийг улсын төсвөөс санхүүжүүлж байна.

Улсын төсвөөс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах үйлчилгээний хөлсийг авахдаа гоц халдварт өвчний тархалтаас хамаарч вакцинжуулалтад хамрагдах мал, амьтны тоо, тэдгээрт шаардагдах вакцины захиалгыг УМЭҮГ-т хүргүүлж, гүйцэтгэлээр санхүүжиж байна.

Малын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг малын тоо, урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйлчилгээний үнийн өсөлт болон мал аж ахуйн салбарт бий болж буй өөрчлөлт шаардлагыг харгалзан тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж байх шаардлагатай байна.

[4] шүлхий, үхрийн мялзан, гахайн мялзан, хонь, ямааны цэцэг, үхрийн цээж, шувууны томуу зэрэг олон улсын байгууллагаас тогтоосон малын гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгө;

[5] малын боом, галзуу, бруцеллёз, сальмонеллёз, цусан халдвар, сүрьеэ, лейкоз, томуу, цусан суулга, листериоз, үхрийн дуут хавдар, хорт салст халуурал, эфемер чичрэг, адууны ям, халдварт цус багадах, уушиг гялтангийн хавьталт халдварт үрэвсэл, сахуу, бог малын дотрын халдварт хордлого, энтеробактериоз, брадзот, сохор догол, шөвөг яр, колибактериоз, ямааны годрон, гахайн ёлом, нохойн гударга өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах эм, биобэлдмэлийн үнэ;

## 1.2. Батлагдсан төсвийг МЭҮН-дэд хуваарилах тогтоосон заавар, аргачлал байдаггүйгээс зардлыг бодитой хуваарилахгүй байна.

Малын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуваарилах тогтоосон заавар, журам байдаггүйгээс мал эмнэлгийн анхан шатны нэгжээс өвчлөл гарах эрсдэл бүхий малын тоог гарган, аймгийн ХХААГ-т хянуулан, нэгтгэж УМЭҮГ-т хүргүүлдэг байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 11 дүгээр тогтоолоор 2017 оны МЭУСАХ зардлыг 236.0 сая төгрөгөөр баталсны дагуу аймгийн ХХААГ-аас МЭҮН-үүдэд олгох төсвийн хуваарийг халдварт өвчний эпизоотоологийн зураглал, харьяа малын тоо, өмнөх жилүүдийн гүйцэтгэл зэргийг харгалзан тооцоолж, аймгийн Засаг даргаар батлуулан мөрджээ.

Аудитаар түүвэрт хамрагдсан хувийн мал эмнэлгүүдийн хувьд мал амьтны халдварт өвчний судалгаа хөтөлж, малын халдварт, празит өвчний зураглалыг гаргасан байхад МЭА аймгийн хэмжээний малын халдварт, празит өвчний зураглалыг гаргаагүй байлаа.

Хэдийгээр батлагдсан төсөвт тааруулан хуваарилалтыг хийж байгаа ч МЭҮН-үүдэд төсөв хэрхэн хуваарилсан нарийн тооцоолол байхгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал, амьтны тоог хэрхэн сонгож байгаа нь тодорхойгүй байна. /Хавсралт № 2/

*Тайхайлбал:*

- *2015-2017 оны урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нохойнд галзуугийн вакцин хийхээр төлөвлөөгүй боловч зарим малчин өрхийн нохойг галзуугийн вакцинд хамруулсан.*
- *2017 оны жилийн эцсийн тэжээвэр амьтдын тооллогоор Сайнцагаан, Гурвансайхан, Сайхан-Овоо сумдад нийт 130 гахай тоологдсон байхад мялзангийн вакцинд хамруулах амьтны тоог судалж төлөвлөгөөнд тусгаагүй байна.*

МЭҮН-үүдийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал, амьтны тоог хуваарилсан төсөвтэй нь сүүлийн 3 жилээр харьцуулж үзэхэд аймгийн дүнгээр вакцинд хамруулах мал, амьтны тоо 2016 оноос 31.2-139.7 мянган толгойгоор буурсан ч батлагдсан төсвийн дүн бууравгүй байна. /Хавсалт №2/

Малын тоо буурсан шалтгаан нь халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээнд хамрагдах бог мал, бод малын тооны өөрчлөлт болон вакцины нөөц, тандалт шинжилгээний зардлын өсөлт зэрэг нөлөөлсөн байна.

График № 6




Цаашид аймгийн ХХААГ-аас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үнэлж, хуваарилах аргачлалыг боловсруулж мөрдөх шаардлагатай байна. Энэ нь өвчлөл гарах эрсдэл бүхий мал, амьтны тоог бодитой үнэлэх, хуваарилалтыг тодорхой болгох ач холбогдолтой юм.

### 1.3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж байгаа ч вакцины орлого, зарлагыг хөтлөөгүйгээс 3,171.0 мянган төгрөгийн вакцин бүртгэлгүй байна.

2017 онд малын тарилга вакцинжуулалтын үйлчилгээний хөлсөнд зарцуулахаар 236,016.0 мянган төгрөг төсөвлөгдөж гүйцэтгэлээр 228,790.2 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 7,225.8 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна. /Хавсралт №5/

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр авч үзэхэд 2015, 2017 онд 400.0-7,222.8 мянган төгрөг хэмнэгдсэн нь 2017 онд сумдад гоц халдварт өвчин гарсан, сохор, догол, галзуугийн вакцин ирээгүй зэргээс шалтгаалсан бөгөөд цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулах шаардлагатай байна. График № 7




Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилтийг Төрийн сан дахь аймгийн ХХААГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 4,685.3 мянган төгрөгийг, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 224,104.9 мянган төгрөгийг зарцуулжээ.

2015-2017 онд тандалт шинжилгээний зардалд нийт 9,522.8 мянган төгрөг зарцуулж, үүнээс тандалт шинжилгээний багаж хэрэгслийн зардалд 2,605.0 мянган төгрөг, Лабораторийн 2016, 2017 оны итгэмжлэлийн зардал 1,300.0 мянган төгрөг, нийт 3,905.0 мянган төгрөгийг зориулалтын бус зардалд зарцуулсан байна. Энэ нь Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[6]- дахь заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Батлагдсан төсвийг үндэслэн аймгийн ХХААГ, сумын Засаг дарга, МЭҮН-тэй гурвалсан гэрээ байгуулан баталгаажуулан ажиллаж байна.

Аймгийн ХХААГ нь МЭҮН-үүдийн санхүүжилтийг олгохдоо Дундговь аймгийн Засаг даргын 2013 оны А/284 дугаар тушаалаар баталсан "Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг олгох, гүйцэтгэлд хяналт тавих журам"-ын 2.4.2[7], 3.1[8]-д заасан анхан шатны баримт материалын бүрдэл, санхүүгийн

[6]Энэ хуулийн15.1.2-т заасан өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

[7]Вакцин био тарилгыг графикт хугацаанд нь тухайн өвчны голомтод өвчлөмтгий малыг хамруулан тарьж, тарилга хийсэн актыг УМЭА маягт 32 –оор үйлдэж, хавсралтад малчнаар гарын үсэг зуруулна. Тарилга хийсэн баримтыг 3 хувь үйлдэж, сумын МЭҮТ-ийн мэргэжилтнээр хянуулан, зохих байгууллагад хүргүүлнэ. Малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт тарилга хийсэн малын төрөл, тоо зарцуулсан вакцины хэмжээ, үнэ үйлчилгээний хөлс зэргийг заавал тэмдэглэнэ.

[8]ХХААЖДҮГ-аас дарах материалыг аймгийн Төрийн санд ирүүлсэн нөхцөлд Аймгийн Засаг даргын нөөцөөс тарилгын үйлчилгээний хөслийг сумдад хуваарилна.

тооцооллын үнэн зөв байдлыг үндэслэн үйлчилгээний хөлсийг сумдад олгох хүсэлтийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст гаргаж, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулжээ.

Аудитад хамрагдсан 7 сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны хуулга, гурвалсан гэрээ, санхүүжилт олгох хуваарь зэрэг анхан шатны баримт материалыг тулган шалгахад анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой дараах алдаа, зөрчлүүд байна. Үүнд:

- *Тарилгад хамрагдсан малын тоог малчны малын эрүүл мэндийн дэвтэр, малд тарилга хийсэн акт, айл өрхийн цуваанд зөрүүтэй бичсэн.*
- *Өрхөд тоологдсон малын тооноос 43293 илүү малд тарилга хийж 11,386.7 мянган төгрөгийн үйлчилгээний хөлс олгосон.*/хавсралт №6 /
- *Гурвансайхан, Цагаандэлгэр, сумдын МЭҮН-үүдийн малын тарилгын цуваанд хяналт хийхэд зарим мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, малын эмчийн гарын үсэг зурагдаагүй байсан.*

Аудитын явцад малын эм бэлдмэл, вакцины агуулахад хяналтын тооллого хийхэд хонины цэцэг өвчний вакцин 73 шил /бог малаар тооцоход 14,600 тун/, шүлхийгийн вакцин 19 шил /бог малаар тооцоход 3,800 тун/ бүртгэлд тусгагдаагүй илүү байсан.

Шүлхийгийн вакцины илүү гарсан шалтгааныг шалгах боломжгүй болсон тул цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

Харин хонины цэцэг өвчний вакциныг анхан шатны баримтуудаас хөөн шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХХААГ 2016 онд Монголд үйлдвэрлэсэн 520.0 мянган тун /1 шилийг 100 тунгаар найруулах/ вакциныг Биокампитаас, ОХУ-д үйлдвэрлэсэн 347.0 мянган тун /1 шилийг 200 тунгаар найруулах/ вакциныг МЭҮГ-аас орлогодон, тухайн ондоо 520.0 мянган тун вакциныг 7 суманд хуваарилж, 347.0 мянган тун вакцины үлдэгдэлтэй тайлан гаргасан байна. /Хүснэгт №2/

Хүснэгт 2
ХХААГ-ын 2016 оны хонины цэцгийн вакцины зарцуулалт

| № | Он | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2016 | 0 | 520.0 | 520.0 | - |
| | | | 347.0 | | 347.0 |
| | **Нийт** | **-** | **867.0** | **520.0** | **347.0** |

Хонины цэцэг өвчний вакцин тарсан үйлчилгээний хөлснөөс вакцины тунгийн зарцуулалтыг хөөн шалгахад 8 сумын 13 МЭҮН 508.2 мянган тун зарцуулж, үйлчилгээний хөлс авсан байна. /Хавсралт №3/

Зарцуулалтын зөрүү 11.8 мянган тун вакцины 6.8 мянган тун вакциныг ХХААГ-ын малын эм бэлдмэл, вакцин хариуцсан нярав сумдаас татан авсан боловч, агуулахын бүртгэлд бүртгэн, санхүүгийн тайланд тусгаагүй, дутагдуулсан зөрчил илэрсэн. Иймд тухайн үед ажил хариуцаж байсан нярав Л.Нарантуяад холбогдох 6.8 мянган тун буюу 367.2 мянган төгрөгийг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон. Харин 5.0 мянган тун вакциныг Цагаандэлгэр сумын Цаст ундарга МЭҮН 2016 онд нөөцөлж 2017 онд зарцуулсан байлаа.

ХХААГ-ын хонины цэцэг өвчний вакцин 2017 онд эхний үлдэгдэл 347.0 мянган тун дээр УМЭҮГ-аас ОХУ-д үйлдвэрлэсэн 2,671.8 мянган тун/1 шилийг 200 тунгаар найруулах/ вакциныг орлогодон, 15 суманд 2,990.8 тун вакцин хуваарилж, үлдэгдэл

28.0 мянган тун вакциныг санхүүгийн тайланд тусгаж, 2018 оны 6 сард УМЭҮГ-т хүргүүлсэн байна.

Хүснэгт №3 Хонины цэцгийн вакцины зарцуулалт

| № | Он | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| | 2017 | 347.0 | 2,671.8 | 2,990.8 | 28.0 |
| | **Нийт** | **347.0** | **2,671.8** | **2,990.8** | **28.0** |

Сумдад хуваарилсан 2,990.8 тун вакцины зарцуулалтыг хөөн шалгахад үлдэгдэл 41.0 мянган тун вакциныг санхүүгийн бүртгэл тайланд тусгаагүй, зөрчил илэрсэн.

Үүнээс нярав Д.Эрдэнэцэцэгт хамаарах 24.6 мянган тун вакцины 14.6 мянган тун вакцин хяналтын тооллогоор тоологдон, 2.2 мянган тун вакцин Эрдэнэдалай суманд /Элбэгдалай МЭҮН-д 2.2 тун, Өлзийсүмбэрэл МҮЭН-д 0.2 мянган тун/, 1.6 тун вакцин Өндөршил суманд /Баян жинст цагаан МЭҮН/, үлдэгдэл 10.0 тун вакцин дутагдуулсан зөрчил илэрсэн тул ажил хариуцсан нярав Д.Эрдэнэцэцэгээр нөхөн төлүүлэхээр 618.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. /Хавсралт №4/

Цагаандэлгэр сумын Цаст-Ундарга МЭҮН нь 5.3 мянган тун хонины цэцэг өвчний вакциныг илүү зарлагадан, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлс 795.0 мянган төгрөгийг илүү авсан зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

*Дээрхи зөрчлүүд нь дараах нөхцөл байдлаас шалтгаалан гарсан байна. Үүнд :*

- *ХХААГ-ийн нярав анх батлагдсан хуваарийн дагуу вакциныг хуваарилж, сумдад олгоод, сумдаас илүү гарч буцаан тушаасан вакциныг орлогодож авалгүй, вакцин дутагдаж байгаа сумдруу ямарч бүртгэл, тооцоо, баримтгүй явуулдаг.*
- *СумдынМЭҮТ-ийн мэргэжилтнүүд тухайн сумын МЭҮН-үүд хэдэн тун вакцин аваад, хэдэн тун вакцин зарцуулж байгаад хяналт тавьж, үлдэгдэл вакциныг тооцон, тооцоо хийж, татан авдаггүй зэрэг холбогдох албан тушаалтнуудын эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсантай холбоотой байна.*

Иймд холбогдох албан тушаалтнуудад вакцины бүртгэлийг хууль, журмын дагуу хөтөлж, вакцины тунгийн тооцоог хийн, МЭҮН-ээс илүү гарсан вакциныг тухай бүр татан авч, стандартын дагуу хадгалж, хамгаалах шаардлагатай байна.

Аудитаар илэрсэн хонины цэцэг өвчний 31.0 мянган тун вакциныг орлогод авч, бүртгэл тайланд тусгаж, баримтжуулан Төрийн аудитын газарт ирүүлэх зөвлөмжийг ХХААГ-т хүргүүллээ.

**БҮЛЭГ 2.** Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаагаас зарим үйл ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулагдахгүй байна.

## 2.1 Хөдөө орон нутагт ХАА-н мэргэжлийн боловсон хүчин дутмагаас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулж чадахгүй байна.

### Боловсон хүчний талаар

Мал эмнэлгийн үйлчилгээг 2018 оны хагас жилийн байдлаар ХХААГ-ын Мал эмнэлгийн алба, Мал эмнэлэг ариун цэврийн лаборатори, 15 сумын МЭҮТ, хувийн хэвшлийн 34 МЭҮН-үүд хариуцан ажиллаж байна.

Мал эмнэлгийн алба нь 8 орон тоотой, 15 сумын ЗДТГ-ын МЭҮТ-т 7, 34 МЭҮН-д их эмч 40, бага эмч 18, мал зүйч 3 нийт 76 хөдөө аж ахуйн мэргэжлийн боловсон хүчин ажиллаж байна.

Дундговь аймгийн 15 сумын ЗДТГ-ын МЭҮТ-ийн орон тоог 2015 оноос хойш Эрдэнэдалай сумыг 3, бусад сумдыг 2 мэргэжилтэнтэй байхаар бууруулан баталсан. 2018 оны байдлаар 7 сумын МЭҮТ-т1 орон тоо дутуу, 10 суманд тус орон тоонд хөдөө аж ахуйн мэргэжлийн бус жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан, бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. /Хүснэгт №4/

Хүснэгт №4 Сумдын боловсон хүчний судалгаа /малын тоо мянган толгойгоор/

| № | Сумын нэр | 2017 оны жилийн эцсийн малын тоо | МЭҮН тоо | МЭҮН-ийн мэргэжлийн боловсон хүчин | МЭҮТ | | Нэг боловсон хүчинд ногдох мал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мэргэжлийн | Мэргэжлийн бус | |
| 1 | Адаацаг | 286.4 | 3 | 5 | 1 | | 47.7 |
| 2 | Баянжаргалан | 122.6 | 3 | 4 | | 1 | 30.6 |
| 3 | Говь-Угтаал | 187.4 | 1 | 1 | 1 | 1 | 93.7 |
| 4 | Гурвансайхан | 259.3 | 2 | 5 | 1 | | 43.2 |
| 5 | Дэлгэрхангай | 184.3 | 1 | 3 | 2 | | 36.9 |
| 6 | Дэлгэрцогт | 183.8 | 1 | 1 | 1 | 1 | 91.9 |
| 7 | Дэрэн | 240.3 | 2 | 6 | | 1 | 40.0 |
| 8 | Луус | 173.3 | 3 | 5 | | 1 | 34.7 |
| 9 | Өлзийт | 283.4 | 3 | 7 | 1 | 1 | 35.4 |
| 10 | Өндөршил | 154.7 | 2 | 2 | 1 | 1 | 51.6 |
| 11 | Сайнцагаан | 382.2 | 4 | 7 | 1 | 1 | 47.8 |
| 12 | Сайхан-Овоо | 189.7 | 1 | 1 | | 1 | 189.7 |
| 13 | Хулд | 266.3 | 2 | 2 | 1 | | 88.8 |
| 14 | Цагаандэлгэр | 128.7 | 2 | 2 | 2 | | 32.2 |
| 15 | Эрдэнэдалай | 550.6 | 4 | 10 | 2 | 1 | 45.9 |
| | | **3,593.0** | **34** | **61** | **14** | **10** | |

Сумдын боловсон хүчний судалгаанаас харахад мал эмнэлгийн үйлчилгээний шуурхай, бэлэн байдлыг хангах үүднээс 2017 онд аймгийн ИТХ-ийн 20 дугаар тогтоолоор нэг малын эмчид ногдох малын тоог 50.0 мянган толгой мал байхаар шинэчлэн баталсан боловч Говь-Угтаал, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Хулд сумдад уг заалт хэрэгжихгүй байна.

Мөн хөдөө орон нутагт хөдөө аж ахуйн мэргэжлийн төрийн албан хаагчийн сул орон тоог байнга зарлаж байгаа боловч холбогдох мэргэжлийн боловсон хүчин очиж ажиллахгүй байна.

Иймд сүүлийн жилүүдэд малын тоо толгой эрчимтэй өсч байгаа байдалд дүгнэлт хийж, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс хөдөө орон нутагт ажиллах мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудлыг бодлогын түвшинд судалж, залуу хойч үеэ бэлдэхэд анхаарч ажиллах шаардлагатайбайна.

***Үйл ажиллагааны талаар***

Мал эмнэлгийн алба нь хөдөө орон нутгийн МЭҮТ болон МЭҮН-үүдийг удирдлага арга зүйгээр хангаж, Монгол мал үндэсний хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ХХАА–н салбарын дэвшүүлсэн тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлж малын өвчнийг эмчлэх, урьдчилан сэргийлэх, хянах, эрүүлжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн ажил үйлчилгээг аймгийн хэмжээнд зохион явуулах ёстой.

Аймгийн ХХААГ, сумдын ЗДТГ нь санхүүгийн тайландаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилтийг бүрэн тусгаж, санхүүжилтийг анхан шатны бүрдэл хангасан ажил гүйлгээнд зарцуулж байгаа боловч мал эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн.

*Үүнд:*

- *Малын вакцин, эм тариа хадгалах хөргүүрийн шингэн дууссан гэсэн шалтгаанаар вакцины хөргүүрийг ажиллуулаагүй;*
- *Хонины цэцэг өвчний вакцин, дуут хавдрын вакцин, боомын вакцин, галзуугийн вакцины шингэлэгчийг ямарч температурхэмжигчгүй өрөө тасалгаанд хадгалж байсан;*
- *Галзуугийн вакцин, шүлхийгийн вакциныг 2 хөргөгчид хадгалсан боловч зохих температурын дагуу хадгалаагүйгээс 10 шил / 2000 бог эсвэл 1000 бод малд хийх/ шүлхийгийн вакциныг хөлдөөсөн. Вакцины хөргөгчийг стандартын шаардлагын дагуу ажиллуулаагүй, термометрийн заалтыг өдөр тутам хөтөлж, хяналт тавиагүй;*
- *Вакцин хариуцсан нярвын тооллогоор хонины цэцэг өвчний вакцин, шүлхийгийн вакцин илүүдэж, зарим бараа материал дутсан;*
- *Мал эмнэлгийн байранд түрээсийн гэрээгүй хувийн малын эмийн сан ажиллуулсан.*

Дээрх зөрчлүүд нь ажил хариуцсан мэргэжилтнүүдийн эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандаж, ажлын хариуцлага алдсан үйлдэл тул Мал эмнэлгийн албаны дарга М.Хүүбаян, дотоод аудит, хяналт шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн О.Ганцэцэг нарт хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн. Мөн Мал эмнэлгийн албаны дарга М.Хүүбаянд ажлын хариуцлага алдаж хөлдөөсөн вакцин

болон тооллогоор дутсан бараа материалыг нөхөн төлүүлэхээр нийт 656.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хөлдөөсөн вакциныг зохих журмын дагуу устгалд оруулж, хариу ирүүлэхийг үүрэг болгосон.

Харин түрээсийн гэрээ байгуулаагүй хувийн малын эмийн сангийн асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлэхийг зөвлөж ажиллалаа.

Цаашид малын вакцин, эм тариаг зохих температурын дагуу хадгалж, термометрийн заалтыг өдөр тутам хөтлөн, хяналт тавьж, хөрөнгийн тооллогыг чанартай хийж, тооцоо бодож баталгаажуулж байх шаардлагатай байна.

Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн үйл ажиллагааг шалгах үед мал, амьтан, түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийн үзлэг шинжилгээ, үйлчилгээний төлбөр 34.9 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. Мөн ариун цэврийн лабораторийн ажилтнууд сумдын малын эмч, малчдаас ирүүлсэн дуудлаганд явж, эмчилгээ туслалцааг төлбөртэй үзүүлсэн боловч Төсвийн тухай хуулийг зөрчин тухайн байгууллагын төсөвт 117.0 мянган төгрөгийн төлбөрийг тушаагаагүй зөрчлүүд тус тус илэрсэн. Дээрхи зөрчлүүдийг арилгуулахаар 151.9 мянган төгрөгийн төлбөрийн актыг тогтоож, хяналт тавиагүй лабораторийн эрхлэгч А.Оюунцэцэгт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Цаашид ХХААГ-ын даргын 2016 оны тушаалаар баталсан “Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээнд ажиллах журам”-ын дагуу ажиллах шаардлагатай байна.

## 2.2 Мал эмнэлгийн эм, биобэлдмэлийн ашиглалт, зарцуулалт, хадгалалтад тавих бүх шатны хяналт хангалтгүй байна.

Аймгийн МХГ нь мал эмнэлэг, малын эмийн сан, мал, мах, болон малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийн, эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлд суурилан, эрсдэл ихтэй газруудын эрсдэлийг бууруулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт, тандалт судалгаа хийх, эрсдэлийн судалгаа, баазыг өргөжүүлэх замаар эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх, эрсдэл багатай газруудад хяналт шалгалтын давтамжийн тоог цөөрүүлэх арга барилаар тухайн онуудад ажилласан байна. Мөн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын эрсдэлийг тодорхойлж, мэдээллийн санг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлэн ажиллажээ.




График 8

Аудитын явцад аймгийн МХГ-ын улсын байцаагч болон зарим сумдын МЭҮТ-ийн улсын байцаагч нартай уулзаж, малын вакцины талаар ярилцлага хийхэд вакцин хийлгэсний үйлчилгээний хөлс олголтод тухай бүр тандалт хийж, малын ийлдсийн шинжилгээ хийх боломж байдаггүй учир бүрэн хяналт тавих боломжгүй, тиймээс вакцин хийлгэсэн хөтөлгөөний малчдын гарын үсэг тамга тэмдэгийг шалгаж дүгнэлт гаргаж өгдөг гэсэн тайлбар өгсөн.

2015 онд Аймгийн МХГ-аас малын вакцинжуулалт, вакцины чанар аюулгүй байдалд сумдын МЭҮТ-ийн улсын байцаагч нартай хамтран тандалт судалгааг хийж дараах дүгнэлтүүдийг өгчээ.

*Үүнд:*

- *Сумдын МЭҮН-үүд хуваарьт вакцинаа иржавахдаа ердийн тээврийн хэрэгслээр иржавдаг,*
- *Сумдын МЭҮН-үүд нь зориулалтын агуулах байхгүй бүгд ердийн агуулахад, болон амбаарт вакцинаа хадгалдаг.*
- *Зарим сумд ахуйн хөргүүр ашиглан вакцинаа хадгалдаг боловч хүрэлцээ багтаамж муутай байдгаас хүйтэн хэлхээний нөхцөл 100% бүрдэхгүй байна гэсэн дүгнэл төгсөн байна.*

Дээрх ярилцлага болон хонины цэцэг өвчний тулгалт, шалгалтын дүнгээс үзэхэд сумдын холбогдох мэргэжилтэн, МХГ нь тухайн МЭҮН хэдэн тун вакцин аваад, хэдэн тун вакцин зарцуулж, хэдэн тунг хорогдолд тооцож, хэдэн тун вакцины үлдэгдэл үлдсэнийг тооцоо хийж, буцаан татаж авдаггүй, зөвхөн вакцины үйлчилгээний хөлс авахаар ирүүлсэн баримт материалын гарын үсэг, тамга тэмдгийн бүрдлийг л шалгаж байна.

МЭҮН-үүдэд олгодог гоц халдварт өвчний вакцины үйлчилгээний хөлсний нотлох баримтыг 2015 онд зөвхөн Мал эмнэлгийн албаны даргын баталсан жагсаалтаар олгодог байсан нь санхүүгийн анхан шатны баримт бүрдлийн шаардлага хангахгүй байсан учраас ХХААГ-ын нягтлан бодогч Б.Энхдөл малчны гарын үсэг зуруулж, тамга даруулж, санхүүгийн анхан шатны бүрдлийг хангуулдаг болсон сайн тал ажиглагдсан.

Мөн ХХААГ-ын вакцины хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг шалгахад, Мал эмнэлгийн албанд сүүлийн 3 жилд МХГ-аас шалгалт хийгээгүй, малын вакцин, эм бэлдмэлийг зориулалтын дагуу хадгалаагүй зөрчил илэрсэн.

Иймд аймгийн 15 сумын хонины цэцэг өвчний 2016 болон 2017 оны вакцины орлого, зарлагад тулгалт хийж, тооцоо хийхэд зөрүүтэй гарсан Сайнцагаан, Адаацаг, Говь-Угтаал, Өндөршил, Эрдэнэдалай, Цагаандэлгэр зэрэг 6 сумын вакцин хариуцсан холбогдох мэргэжилтэн, улсын байцаагч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг удирдах албан тушаалтнуудад хүргүүллээ.

Аудитын хамрах хугацаанд аймгийн ИТХ болон аймгийн ЗД-аас мал эмнэлгийн үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан хамтарсан хяналт шалгалтыг огт зохион байгуулаагүй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд малын вакциныг стандарт, шаардлагын дагуу чанартай хадгалах нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах чухал ач холбогдолтой юм.

Иймд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль шинээр хэрэгжиж байгаатай холбогдуулан малын вакцины хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад холбогдох мэргэжлийн хүмүүс оролцуулсан хяналт, шалгалтыг хийж байх хэрэгтэй байна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт өгчбайна. Үүнд:

1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс зарцуулах төсвийн саналыг хүргүүлсэн хэмжээнээс 30.2-59.6 хувиар бууруулан баталж байна.
2. Батлагдсан төсвийг МЭҮН-дэд хуваарилах тогтоосон заавар, аргачлал байдаггүйгээс малын тоо, өмнөх жилүүдийн гүйцэтгэл зэргийг харгалзан хуваарилж байна.
